



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/64

Хархорин сум

**Төлөвлөгөөт халдваргүйтгэл, сэг зэм устгах
арга хэмжээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/242 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн төлөвлөгөөт халдваргүйтгэл, хорогдсон малын сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах, хийж гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж, орчны цэвэрлэгээг хийхэд малчид, иргэдийг оролцуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Улсын болон орон нутгийн чанартай зам дагуух, болон цуглуулсан мал, амьтны сэг зэмийг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлэн мэдээг тухай бүрт нь мэдээлж ажиллахыг Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Хархорин салбар дахь менежер (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

4. Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэн ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

5. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж, булж устгах ажлын гүйцэтгэл чанарт хяналт тавин ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Баатарсүрэн), мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Э.Нарангарав) нарт тус тус даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Батчулуун), уг ажилд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

